МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр Дугаар 26/01 Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалт, “Монгол Даатгал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.1 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч батлсугай.
2. 2026 онд Компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ОДОНГЭРЭЛ

МОНГОЛ УЛС

2032317 ... 9013120961

Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990
www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр Дугаар 26/02 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
   1. Громов Сергей Борисович
   2. Ишхүүгийн Дариймаа
   3. Жамбалын Эрдэнэтуяа
   4. Лизунова Таня
   5. Огай Наталья Юрьевна
   6. Энхсайханы Алтанзул

   Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
   1. Батмөнхийн Мөнхзул
   2. Настын Тэмүүлэн
   3. Дамдингийн Болормаа

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж "Даатгалын тухай хууль"-ийн 55.1, СЗХ-ны 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"-д заасны дагуу Компанийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл авч ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.

5. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛС МОНГОЛ ДААТГАЛ ХК 2032217 9011020961

ХУРЛЫН ДАРГА Ч.ОДОНГЭРЭЛ

Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990
www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр Дугаар 26/03 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.13 дахь заалт, "Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.5 дахь заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг тус тогтоолын хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ОДОНГЭРЭЛ

МОНГОЛ УЛС МОНГОЛ ДААТГАЛ ХК 2032317 9010120961

“Монгол Даатгал” ХК-ийн 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 26/03 тоот тогтоолын Хавсралт

МОНГОЛ УЛС
МОНГОЛ ДААТГАЛ ХК
2032317 9019120961

## “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

| № | Зардлын зүйл | Сарын цалин, ₮ | Нийт төсөв, ₮ |
|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн гишүүд | 792,000 | 47,520,000 |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хроооодын хурлын цалин | 100,000 | 4,000,000 |
| 3 | Эчнээ санал хураалтын цалин | 200,000 | 6,000,000 |
| 4 | ТУЗ-ийн хуралтай холбоотой бусад зардал | 3,000,000 | 3,000,000 |
| | **Нийт төсөв** | | **60,520,000** |

МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 30 өдөр | Дугаар 26/04 | Улаанбаатар хот

**Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.1 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.22, 7.45, 7.52, 7.53 дахь хэсгүүд, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тус тус өөрчлөлт оруулж, 7 дугаар зүйлийн 7.32.23 дахь хэсэгт хавсралтад зааснаар нэмж оруулсугай.

2. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Үйл ажиллагааны газар Хуулийн албанд даалгасугай.

МОНГОЛ УЛС МОНГОЛ ДААТГАЛ ХК 2032317 9019120961

ХУРЛЫН ДАРГА Ч.ОДОНГЭРЭЛ